

## Монголбанканд

### Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүний 2023 оны III улирлын тайлан

Хараат бус гишүүн Александр Пикер

Александр Пикер, миний бие 2021 оны 12 сарын 23-нд Голомт банк (цаашид “Банк” гэх)-ны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Хараат бус гишүүнээр сонгогдсон.

Миний бие 2023 оны 3 дугаар улиралд бүх ТУЗ-ийн болон гишүүн болох хороодын хуралд цахимаар болон биечлэн оролцсон.

Тус хугацаанд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- Холбогдох этгээдийн хэлцлийг хянах, тухайлбал ашиг сонирхлын зөрчлийг ажиглах – илрээгүй.
- Дотоод аудитын төлөвлөгөө, тайлан болон төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах.
- Зээлийн хүсэлтийг шалгах
- Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны даргаар ажиллах.

Огноо	Уулзалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
20.07.2023	ТУЗ-ийн хороодын хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- Удирдлагын багийн мэдээлэл</li><li>- Хүний нөөцийн тайлан (Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо)</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан</li><li>- Аудитын хорооны тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн
21.07.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- 2023 оны эхний хагасын санхүүгийн үр дүн</li><li>- Макро эдийн засгийн мэдээлэл</li><li>- Дижитал бүтээгдэхүүний танилцуулга</li><li>- Санхүүжилт (урт хугацааны зээл)-ийн мэдээлэл</li><li>- Тогтвортой санхүүжилтийн танилцуулга</li><li>- Олон улсын банкны газрын Бизнес төлөвлөгөө</li><li>- Аудитын хорооны 2023 оны 2-р улирлын тайлан</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 2-р улирлын тайлан</li><li>- Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны 2023 оны 2-р улирлын тайлан</li><li>- Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 2-р улирлын тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн

Аудитын хорооны гишүүний хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Аудитын хороо нь 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдөр болон 8 дугаар сарын 18-ны өдрүүдэд хоёр удаа хуралдаж нийт 9 асуудал хэлэлцсэн.

Огноо	Хэлэлцсэн асуудал	Санал
20.07.2023	Холбоотой талын хагас жилийн тайлан	Хэлэлцсэн
	Африкийн Бенин улсаас хийгдсэн цахим луйврын гүйлгээ	Хэлэлцсэн
	Цахим сувгийн аюулгүй байдлын аудитын танилцуулга	Хэлэлцсэн
	Иргэдийн зээлийн автоматжуулалтын процессын аудитын тайлан	Хэлэлцсэн
	Салбарын аудитын нэгтгэсэн тайлан	Хэлэлцсэн
	Дотоод аудитын үйл ажиллагааны /ДАГ, Дата анализын алба/, гүйцэтгэлийн тайлан, 2023 оны 2-р улирлын төсвийн гүйцэтгэл, 2023 оны 3, 4-р улирлын ажлын төлөвлөгөө	Хэлэлцэж баталсан
18.08.2023	Санхүүгийн гүйцэтгэл 2023 оны 7 сарын байдлаар	Хэлэлцсэн
	Өрсөлдөгчийн судалгаа	Хэлэлцсэн
	Монголбанкны газар дээрх хяналт шалгалтын үр дүн	Хэлэлцсэн

ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд дараах зүйлсийг онцолсон. Үүнд:

- Дотоод аудитор (ДАГ-ын захирал) солигдсонтой холбогдуулан дотоод аудитын мэргэжлийн ур чадварыг өндөр түвшинд байлгахыг онцлон тэмдэглэв.

- Санхүүжилтийн тухай хэлэлцүүлэгт өөрийн хувь нэмрээ оруулсан.

- Харьцуулалт хийх боломжтой банкуудад хийсэн харьцуулсан судалгаа.

Миний бие Хараат бус гишүүний хувьд аудитын тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг сайтар судалж Дотоод аудитын газрын захирлын гүйцэтгэсэн онц ажлыг магтсан.

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 4 удаа хуралдаж, нийт 9 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.07.20
- 2023.08.16

- 2023.09.06
- 2023.10.13

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй зээлдэгчийн хүсэлттэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

Ашиг сонирхлын зөрчлийн гүйлгээ:

Тус тайлант хугацаанд хийсэн хэлцлийн бүх холбогдох мэдээллийг хүлээн авч асуудалд дэмжсэн санал өгсөн.

- ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлуудад Захирлууд болон удирдлагын багийн гишүүд хамт оролцож, хэлэлцээрт оролцох нь нээлттэй байдаг. Мөн ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого болон үр дүнгийн талаар чөлөөтэй асуулт асуух боломжоор хангагдсан. Шаардлагатай тохиолдолд зохих хэмжээний шүүмжлэл хийж болдог.

- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын хурлын өмнө гишүүдэд нарийвчилсан мэдээдэл бэлтгэх, хүргэх асуудлыг хариуцдаг. Гишүүд мэдээллээр маш сайн хангагдсан байдаг бөгөөд энэ нь хурлыг үр дүнтэй болгоход чухал хувь нэмэр оруулдаг.

- Банкны бүтэц зохион байгуулалт нь сайжирсаар байгаа бөгөөд банк, тэр дундаа Дотоод аудитын газар нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн, ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд дараах зүйлсийг онцолмоор байна. Үүнд:

- Миний мэдэж байгаачлан ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь Банкны эрх ашгийн төлөө, шударгаар гардаг болохыг баталж байна.
- ТУЗ нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.
- ТУЗ нь ээдрээтэй асуудлууд дээр удирдамж өгч ажилладаг.
- Тайлант хугацаанд миний бие Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөх аливаа буруутай үйлдэл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит хурал хийх шаардлага гаргаагүй.
- ТУЗ болон Удирдлагын баг нь гаргасан шийдвэр, түүний үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- Банкны удирдлага одоогийн байдлаар үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна.
- Миний бие шийдвэр гаргахад хангалттай мэдээллийг хүлээн авсан.

Гарын үсэг зурсан:

-----  
Александр Пикер

**Монголбанканд  
Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны III улирлын тайлан**

Хараат бус гишүүн Антонио Лопез Абелло

Миний бие Antonio López Abelló нь Голомт банк (“Голомт” буюу “Банк”)-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн (“ТУЗ”) хараат бус гишүүн болно.

Миний бие дараах (i) ТУЗ-ийн хурлууд, (ii) Эрсдэлийн хороо, Аудитын хороо болон (iii) Нэр дэвшүүлэх хороо (“Хороод”)-ны хурлуудад цахим хэлбэрээр оролцсон болно:

Огноо	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
20.07.2023	ТУЗ-ийн хороодын хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- Удирдлагын багийн мэдээлэл</li><li>- Хүний нөөцийн тайлан (Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо)</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан</li><li>- Аудитын хорооны тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн
21.07.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- 2023 оны эхний хагасын Санхүүгийн тайлан</li><li>- Макро эдийн засгийн мэдээлэл</li><li>- Дижитал бүтээгдэхүүний танилцуулга</li><li>- Санхүүжилт /урт хугацааны зээл/-ийн мэдээлэл</li><li>- Тогтвортой санүүжилтийн танилцуулга</li><li>- Олон улсын банкны газрын Бизнес төлөвлөгөө</li><li>- Аудитын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 4 удаа хуралдаж, нийт 9 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.07.20
- 2023.08.16
- 2023.09.06
- 2023.10.13

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй зээлдэгчийн хүсэлттэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

2023 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо хуралдаж Хүний нөөцийн шинэчлэлийн тайланг хэлэлцсэн.

Дээр дурдсан бүх асуудлыг Голомт банкны захирлууд болон Голомт компанийн удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй хэлэлцсэн гэдгийг онцлон хэлэх ёстой. ТУЗ болон түүний гишүүд миний мэдлэгийн дагуу, надад өгсөн мэдээлэлд үндэслэн Голомт банкны гол оролцогч талуудын эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг хичээж ажилласан.

Дээр дурдсанаас гадна Голомт банкны ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагын хувьд дараах зүйлийг онцолж байна. Үүнд:

- Миний туршлагаас банкны аль нэг ажилтан, ТУЗ-ийн бусад гишүүд болон/эсвэл хувьцаа эзэмшигчид ашиг тусыг нь авч болох асуудлыг ТУЗ-өөс тогтоосон тохиолдолд би эдгээр асуудалд заавар, санал өгөх бүрэн эрх чөлөөтэй байсан. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн гишүүдийн санал, хүсэлт, зөвлөмжийг тогтмол авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.
- Тайлангийн хугацаанд Би Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Банкинд сөргөөр нөлөөлөх аливаа буруутай үйлдлийг илрүүлээгүй. Тиймээс би ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах шаардлага тавиагүй.
- ТУЗ, Хорооны хуралд удирдлага болон Захирлууд хамтран оролцдог. Хэлэлцүүлэг нээлттэй явагддаг бөгөөд ТУЗ-ийн гишүүний тавьсан хүсэлт, шаардлагыг ажилтнууд хэрэгжүүлж ажилладаг. ТУЗ-ийн гишүүд мөн гүйцэтгэх удирдлагын бодлого, үр дүнгийн тухайд чөлөөтэй асууж болно.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хурлын өмнө ТУЗ-ийн гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавидаг. Гишүүдэд холбогдох хурлын өмнө хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл хүргэдэг.
- Миний мэдэхээр ТУЗ болон банкны удирдлагууд үйл ажиллагаагаа ил тод явуулж ирсэн.
- ТУЗ-ийн гишүүдэд танилцуулсан санхүүгийн мэдээлэлд үндэслэн харвал Голомт нь 2023 оны 3-р улиралд ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хуримтлагдсан ашиг хэлбэрээр хөрөнгө босгох чиглэлээр амжилттай үргэлжлүүлэн ажиллаж байна.
- 2022 оны 11 дүгээр сард Голомт банк IPO хийхтэй холбогдуулан санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хүндрэл, Монгол Улсын институциональ хөрөнгө оруулагчдын нөөц хязгаарлагдмал байгаа нөхцөлд Голомт банкны хувьцааны үнийг хэрхэн нэмэгдүүлэх талаар ТУЗ-ийн гишүүд болон удирдлагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Миний бие 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдөр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх (шууд үйлчлэлтэй) хүсэлтээ өгсөн.

Хүндэтгэсэн,

-----

Антонио Лопез Абелло  
Хараат бус гишүүн

**Монголбанканд**  
**Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны III улирлын тайлан**

Хараат бус гишүүн Жэймс Б. Двайер III

Миний бие James B. Dwyer III (Жеймс Б.Двайер III) нь 2018 оны 3 дугаар сард Голомт банкны ("Голомт" буюу "Банк") Төлөөлөн удирдах зөвлөлийн ("ТУЗ") хараат бус гишүүнээр томилогдсон.

Миний бие 2018 оны 3 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сар хүртэл нийт ТУЗ-ийн хурал болон цөөн удаагийн хурлаас бусад нийт Банкны Хороодын хурлуудад биечлэн оролцсон. 2021 оны 2 дугаар сараас хойшхи хурлуудад цахим хэлбэрээр 2023 оны 7 дугаар сард болсон ТУЗ-ийн хуралд биечлэн оролцсон болно.

Огноо	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
20.07.2023	ТУЗ-ийн хороодын хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- Удирдлагын багийн мэдээлэл</li><li>- Хүний нөөцийн тайлан (Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо)</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан</li><li>- Аудитын хорооны тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн
21.07.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- 2023 оны эхний хагасын Санхүүгийн тайлан</li><li>- Макро эдийн засгийн мэдээлэл</li><li>- Дижитал бүтээгдэхүүний танилцуулга</li><li>- Санхүүжилт /урт хугацааны зээл/-ийн мэдээлэл</li><li>- Тогтвортой санүүжилтийн танилцуулга</li><li>- Олон улсын банкны газрын Бизнес төлөвлөгөө</li><li>- Аудитын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн

Аудитын хорооны даргын хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Аудитын хороо нь 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдөр болон 8 дугаар сарын 18-ны өдрүүдэд хоёр удаа хуралдаж 9 асуудал хэлэлцсэн.

Огноо	Хэлэлцсэн асуудал	Санал
20.07.2023	Холбоотой этгээдийн хагас жилийн тайлан	Хэлэлцсэн
	Африкийн Бенин улсаас хийгдсэн цахим луйврын гүйлгээний дүн шинжилгээ	Хэлэлцсэн
	Цахим сувгийн аюулгүй байдалд хийсэн аудитын тайлан	Хэлэлцсэн
	Иргэдийн зээлийн процесс автоматжуулалт төсөлд хийсэн аудитын тайлан	Хэлэлцсэн
	Салбарын үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүн	Хэлэлцсэн
	Дотоод аудитын үйл ажиллагааны /ДАГ, Дата анализын алба/ гүйцэтгэлийн тайлан, зардлын гүйцэтгэл, 2 дугаар хагасын ажлын төлөвлөгөө	Хэлэлцэж, баталсан
18.08.2023	2023 оны 7 дугаар сарын байдлаарх Санхүүгийн гүйцэтгэл	Хэлэлцсэн
	Өрсөлдөгчийн судалгаа	Хэлэлцсэн
	Монголбанкны газар дээрх хяналт шалгалтын үр дүн	Хэлэлцсэн

Хараат бус гишүүний хувьд дараах зүйлсийг онцолж хэлсэн:

- Голомт банкны 2023 оны 5 сарын байдлаарх санхүүгийн үр дүнг хянаж, Чанаргүй зээлийн хувь өсөж байгаа шалтгааны талаар асууж, хариултаа авсан.
- PwC-с өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, эдгээр зөвлөмжүүдийг биелүүлэхийг сануулсан.
- Монголбанканд хүргүүлэх Тогтворжуулах төлөвлөгөөний шинэчлэлтийг хянасан.
- Дотоод аудитын газраас (ДАГ)-аас танилцуулсан аудитын тайлантай дэлгэрэнгүй танилцаж, хянасан.
- Мэдээллийн системийн patch удирдлага сул байснаар ямар эрсдэл учирч болох талаар асуулт асууж, хариулт авсан.
- Дотоод аудитын үйл ажиллагаа (ДАҮА)-ны тайлан, зардлын гүйцэтгэл, 2023 оны 3, 4-р улирлын ажлын төлөвлөгөөтэй танилцаж, баталсан.
- А.Туяаг Дотоод аудитын газрын захирал, Б.Хишигжаргалыг ДАГ-Ерөнхий аудитын хэлстийн захирлаар томилох саналтай танилцаж, хянасан. Товч намтар (CV), ололт амжилт, банканд оруулсан хувь нэмэртэй танилцаж, саналыг дэмжсэн.

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь 2023 оны 7 дугаар сарын 20-нд хуралдаж, (i) Хүний нөөцийн шинэчлэлийн тайлантай танилцсан.

Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд дараах байдлаар оролцсон. Үүнд:

Тус улиралд Эрсдэлийн удирдлагын хороо нь 4 удаа хуралдаж, нийт 9 асуудлыг дараах өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.

- 2023.07.20
- 2023.08.16
- 2023.09.06
- 2023.10.13

Санхүүжилтийг батлахад нарийвчлан хянаж, санал хураалтыг цахимаар авдаг. Асуудлуудын ихэнх нь 20.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй зээлдэгчийн хүсэлттэй холбоотой Зээлийн хорооны шийдвэрийг хянан шалгах талаар байв.

Цаашдын үйл ажиллагаанд харгалзах дараах зөвлөмжийг хорооноос гаргасан. Үүнд:

- Ашиг сонирхлын зөрчилтэй гүйлгээ:

Тус тайлант хугацааны 10 дугаар сарын 13-ны өдөр хийсэн хэлцлийн бүх холбогдох мэдээллийг хүлээн авч асуудалд дэмжсэн санал өгсөн.

ТУЗ-ийн гишүүний хувьд би дараахь зүйлийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Үүнд:

- Миний мэдэж байгаагаар Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрүүд нь зөвхөн банкны эрх ашгийн төлөө, өөр бусад ашиг сонирхолгүйгээр гардаг гэдгийг баталж байна.
- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.
- ТУЗ-өөс засч сайжруулах боломжтой асуудлыг олж харсан тохиолдолд бид ТУЗ-ийн түвшинд хэлэлцүүлж, үйл ажиллагааг сайжруулах чиглэл өгч, эргэн мэдээлэх хугацаа өгдөг. Гүйцэтгэх удирдлагын баг эдгээр хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.
- Би тайлант хугацаанд тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд банкинд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн буруутай үйлдлийг илрүүлээгүй. Иймд ямар нэгэн асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах хүсэлт гаргаагүй.
- ТУЗ болон Удирдлагын баг нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь ил тод мэдээлдэг.
- ТУЗ-өөс тайлант хугацаанд гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс маш сайн судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.
- Надад асуулт эсвэл нэмэлт тодруулга авах шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ болон Удирдлагын багийн гишүүд зохих мэдээллийг өгч хамтарч ажилладаг.
- 2022 оны 11-р сард амжилттай IPO хийсний дараа Банкны удирдлага 2022 он болон 2023 оны эхний 9 сарын хугацаанд Үйл ажиллагааны ашгаа амжилттай бүрдүүлж чадсан. Банк нь Үйл ажиллагааны ашгаа дээд амжилт тогтоосон хэмжээнд нэмэгдүүлсээр байна. Гадаад эх үүсвэрийн хүртээмж хангалттай хэмжээнд байна.
- IPO амжилттай болсонтой холбогдуулан банкны олон нийттэй харилцах харилцааг ихээхэн онцолж байсан. Голомт банкиг “The Banker” сэтгүүлээс 2022 оны



“Монголын шилдэг банк”-аар шалгаруулсан нь ч мөн адил энэхүү олон нийттэй харилцах ажиллагааны хүчин чармайлтын илэрхийлэл байлаа. Банкны "Сайн сайхныг санхүүжүүлнэ" хэмээх уриа, Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үйл ажиллагааг дэмжих, дижитал эрин дэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарлаа хандуулж урамшууллаа.

- Банкны бизнес төлөвлөлт, төсөвлөлт нь мөн үлгэр жишээ болсон. Шаардлагатай өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийсэн. Төлөвлөгөөний зөрүүг хянаж, стратегид тухай бүрт нь өөрчлөлт оруулдаг. Сайн стратегийг тодорхойлохдоо бусад 4 том банктай харьцуулсан харьцуулалтыг тогтмол хийдэг.
- ТУЗ, Хорооны хуралд удирдлагын баг болон захирлууд хамтран оролцож, нээлттэй хэлэлцүүлэг явуулдаг. ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого, үр дүнг чөлөөтэй асууж болно. Шаардлагатай бол эерэг шүүмжлэл хийх боломжтой.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хуралдааны өмнө ТУЗ-ийн гишүүдэд гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавьдаг. ТУЗ-ийн гишүүд хурлын өмнө дэлгэрэнгүй мэдээллээр хангагдсан байдаг нь хурлыг үр дүнтэй болгодог.
- Банкны бүтэц зохион байгуулалт тасралтгүй сайжирч, нэлээд үр дүнтэй ажиллаж байна.
- Банк 2022 оны санхүүгийн тайландаа PricewaterhouseCoopers (PwC)-аас шаардлага хангаагүй дүгнэлтийг хүлээн авсан. PwC мөн дотоод хяналтыг үргэлжлүүлэн хийсээр байна.

Хүндэтгэсэн,

-----

James B. Dwyer III  
Хараат бус гишүүн

**Монголбанканд  
Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний 2023 оны III улирлын тайлан**

Хараат бус гишүүн Роберт В.Ван Свитен

Миний бие, Роберт В.Ван Свитен, 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Голомт банкны (“Голомт” буюу “Банк”) Төлөөлөн удирдах зөвлөлийн (“ТУЗ”) хараат бус гишүүнээр томилогдон мөн тус өдөр Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан. Нэр дэвшүүлэх хорооны даргаар мөн томилогдсон.

Миний бие 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны бүх хуралд цахим хэлбэрээр оролцож 2023 оны 7 дугаар сарын 20, 21-ний өдөр зохион байгуулагдсан ТУЗ-ийн хуралд биечлэн оролцсон.

Огноо	Хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал
20.07.2023	ТУЗ-ийн хороодын хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- Удирдлагын багийн мэдээлэл</li><li>- Хүний нөөцийн шинэчлэлийн тайлан (Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо)</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан</li><li>- Аудитын хорооны тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн
21.07.2023	ТУЗ-ийн хурал /ээлжит/	<ul style="list-style-type: none"><li>- 2023 оны эхний хагасын Санхүүгийн тайлан</li><li>- Макро эдийн засгийн мэдээлэл</li><li>- Дижитал бүтээгдэхүүний шинэчлэлийн танилцуулга</li><li>- Санхүүжилт /урт хугацааны зээл/-ийн шинэчлэл</li><li>- Тогтвортой санүүжилтийн шинэчлэл</li><li>- Олон улсын банкны хэлтсийн бизнесийн төлөвлөгөө</li><li>- Аудитын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li><li>- Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 2 дугаар улирлын тайлан</li></ul>	-	Хэлэлцсэн

Нэр дэвшүүлэх хороо нь 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдөр болон 8 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж 1 асуудал хэлэлцсэн.

Огноо	Хэлэлцсэн асуудал	Санал
28.08.2023	Байгууллагын банкны газрын захирлаар Б.Сугар-Эрдэнийг томилох тухай	Дэмжсэн

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд би дараахь зүйлийг онцлон тэмдэглэхийг хүсч байна:

- Миний мэдэж байгаачлан Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрүүд нь зөвхөн банкны эрх ашгийн төлөө, өөр бусад ашиг сонирхолгүйгээр гардаг гэдгийг баталж байна.
- ТУЗ-ийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчдаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.
- ТУЗ-өөс засч сайжруулах боломжтой асуудлыг олж харсан тохиолдолд бид ТУЗ-ийн түвшинд хэлэлцүүлж, үйл ажиллагааг сайжруулах чиглэл өгч, эргэн мэдээлэх хугацаа өгч ажилладаг. Гүйцэтгэх удирдлагын баг эдгээр хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна.
- Би тайлант хугацаанд тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд банкинд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн буруутай үйлдлийг илрүүлээгүй. Тиймээс би ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал хуралдуулах хүсэлт гаргаагүй.
- ТУЗ болон Удирдлагын баг нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь ил тод мэдээлдэг.
- ТУЗ-өөс тайлант хугацаанд гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс маш сайн судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.
- Надад асуулт эсвэл нэмэлт тодруулга авах шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ болон Удирдлагын багийн гишүүд зохих мэдээллийг өгч, хамтарч ажилладаг.
- ТУЗ, Хорооны хуралд удирдлагын баг болон захирлууд хамтран оролцож, нээлттэй хэлэлцүүлэг явуулдаг. ТУЗ-ийн гишүүд удирдлагын бодлого, үр дүнг чөлөөтэй асууж, шаардлагатай бол эерэг шүүмжлэл хийх боломжтой.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ болон хорооны хуралдааны өмнө ТУЗ-ийн гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэхэд хяналт тавьдаг. Гишүүд маш сайн мэдээллээр хангагдсанаар хуралд үр дүнтэй хувь нэмэр оруулж чаддаг.

Хүндэтгэсэн,

---

Роберт В.Ван Свитен  
Хараат бус гишүүн